

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



# **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн  
2017 оны 12 дугаар сарын 31-нээр  
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

**Аудитын код: БӨА-2018/114/СТА-ТШЗ**

2018 оны 2 дугаар сар

# ЦЭНГЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас:70422954

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930

Аудитор: Д.Назгүл  
99427301

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Хаяг:** Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар

**Цахим хуудас:** [www.bayan-ulgii.gov.mn](http://www.bayan-ulgii.gov.mn)

2018 оны 2 дугаар сар

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 28-наас 2018 оны 2 дугаар сарын 02-ны хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймгийн аудитын газрын аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 23-нд аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

Аймгийн аудитын газар аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 28-наас 2018 оны 2 дугаар сарын 2-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 05-нд Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Боловсролын тухай хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль” “СӨБ-ын тухай хууль” зэрэг

хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол Улсын “СӨБ-ын тухай” хуулийн 3-р зүйлийн 3.1-д “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Байгууллагын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн эрхэлэгч төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны төсвийг аймгийн ТЭЗ-ийн Тусгай зориулалтын шилжүүлэгийн багцаас санхүүжүүлэн аймгийн Төрийн сангаар дамжуулан Цэнгэл сумын төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 14-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан байгууллагын даргын тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь санхүүгийн үйл ажиллагаандаа программ нэвтрүүлсэн. Аколоус програмаар нягтлан болох бүртгэлийг хөтөлдөг ба мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Тусгай зориулалтын шилжүүлэгийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн төсвийн захирагч нь 2017 онд 335,9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ.

Төсвийн гүйцэтгэлээр 335,9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 1,4 сая төгрөгөөр, тогтмол зардал 0,6 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 0,04 сая төгрөгөөр, томилолтын зардал 0,02 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 0,04 сая төгрөгөөр тус тус буурсан дүнтэй бол, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0,08 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 0,6 сая төгрөгөөр, нормативт зардал 0,5 сая

төгрөгөөр, , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 0,01 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 17,4 сая төгрөгөөр тус тус өссөн дүнтэй байна.

Тус сургуулийн 2017 оны орон тоог удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 16, үйлчилэх ажилтан 9 бүгд 26 орон тоогоор баталсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 16, үйлчлэх ажилтан 11 буюу бүгд 28 орон тоогоор ажиллуулж батлагдсан орон тоог 2-оор хэтрүүлсэн байна.

### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн тул 2017.12.20 №47 тоот албан шаардлага өгч, 319,0 сая төгрөгийн алдаа, зөрчлийн биелэлтийг хангуулсан байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-1-r tsetserleg файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого-санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ-ийн зардал, хоол, түлш халаалт, гэрэл цахилгаан,тэтгэмжийн зардлын данс зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Ажил гүйлгээ бага тул тус байгууллагын нийт орлого, нийт хөрөнгийг 100 хувь, нийт зардлын 94,0 хувийг хамруулж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав.

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

**Материаллаг алдаа зөрчлүүд:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тус цэцэрлэг нь батлагдсан орон тоог хэтрүүлж, 1 туслах тогоочийн, 1 сав угаагчийн орон тоог илүү ажиллуулж Төсвийн тухай хуулийн 6.1, 16.5.2, 16.5.3 дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

**Шийдвэрлэсэн:** Батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах, УИХ-ын “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2017 оны 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах; талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**  
Материаллаг бус алдаа, зөрчил илэрээгүй.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**  
Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй болно.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**  
Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**  
Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**  
Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж ажилласан зөрчил илэрсэн тул зөвлөмж өгсөн.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**  
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг түвшингээс доогуур, санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл бага бөгөөд Цэнгэл сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, хавсралтууд хуудас,  
байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

2018.02.04

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН  
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

**Аудитын нэр:** Өлгий сумын 3-р БДС-ийн 2014 оны санхүүгийн тайлан

**Аудитын код:** БӨЛ-2015/04-СТА-ТШЗ

**Аудитын багийн нэр:** Аудитор Д.Назгүл

**Тайлант жил :** 2014 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэн огноо	Тайлбар
---	---	---------------------	---------

		Анхан шатны хяналт	Хоёрдах шатны хяналт	
1	Аудитын тайлан	✓	✓	
2	Ерөнхий аудиторроор гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн <b>Аудитын гэрчилгээ</b>	✓	✓	
3	Менежментийн захидал			Байхгүй
	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	✓	✓	
4	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан	✓	✓	
5	Акт, албан шаардлагын төсөл			✓
6	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			Байхгүй

Бэлтгэсэн: Аудитор

Д.Назгүл

2015.02.02

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер :

Хоёрдах шатны хяналт хийсэн Тэргүүлэх аудитор:

Аудитын менежерийн санал:

Тэргүүлэх аудиторовын санал: